



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/500

Булган сум

Бөхийн цол олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 819 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114 жил, Ардын хувьсгалын 104 жил, Ардчилсан хувьсгалын 35 жил, Булган аймаг байгуулагдсаны 87 жилийн ойн аймгийн баяр наадмын хүчит бөхийн барилдаанд 128 бөхөөс 7 даван түрүүлсэн Булган аймгийн Сайхан сумын харьяат Батсуурь овогтой Бат-Эрдэнэд “Аймгийн арслан”, 6 давж үзүүлэсэн Булган аймгийн Могод сумын харьяат Мягмаржаргал овогтой Өсөхбаярт “Аймгийн заан”, 5 давж шөвгөрсөн Булган аймгийн Хишиг-Өндөр сумын харьяат Баттөмөр овогтой Бэх-Очир, Булган аймгийн Хангал сумын харьяат Сайнбаяр овогтой Жавхлан нарт “Аймгийн начин” цол тус тус олгосугай.

2.Шинээр цол авсан хүмүүст цолны энгэрийн тэмдэг, үнэмлэх олгохыг Үндэсний бөхийн салбар хорооны дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР